БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## БАЯНГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**АУДИТЫН КОД: БНА-2021/17/СТА/ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор хот

2021 он


Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням

Утас: 99442140 Цахим хаяг: tseenyma@audit.gov.mn

Аудитор: Н.Бүнчинсүрэн

Утас: 99049866 Цахим хаяг: bunchinsurenn@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт ........................................ 3
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан ........................................ 5
2.1.Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан ........................................ 5
**2.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан** ........................................ 6
2.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан ........................................ 7
2.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........................................ 9
2.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........................................ 9
2.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтын тайлан ........................................ 11
3.Аудитын тайлан ........................................ 12
3.1. Ерөнхий зүйл ........................................ 12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ........................................ 12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт ........................................ 12
3.4. Материаллаг байдал ........................................ 13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ........................................ 13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ........................................ 14
3.7. Шилэн дансны мэдээлэл ........................................ 16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........................................ 17
3.9. Аудитын илрүүлэлт ........................................ 17
Залруулсан алдаа ........................................ 17
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил ........................................ 17
3.9. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд ........................................ 18
4. Менежментийн захидал ........................................ 19
5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ........................................ 21

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2021.02.25 № 2/157

танай ______________ -ны №______________ -т

БАЯНГОВЬ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Д.ОТГОНЖАРГАЛ ТАНАА

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянговь сумын ЗДТГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянговь сумын ЗДТГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 14 зорилтын хүрээнд 24 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Баянговь Засаг дарга баталж, гүйцэтгэлийн тайланг Баянговь сумын ЗДТГ-ын дарга тайлагнасан байна.

2021 А4 ТООТ

005020163

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, заавын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

## Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

### 2.1.АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **64,193,078.00** | **70,036,795.00** |
| **33** | **АВЛАГА** | 1,818,833.00 | 1,800,000.00 |
| **335** | **Бусад авлага** | 1,818,833.00 | 1,800,000.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 1,818,833.00 | 1,800,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 62,374,245.00 | 68,236,795.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 2,500,000.00 | 4,000,000.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 2,500,000.00 | 4,000,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 39,560,245.00 | 43,922,795.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,557,175.00 | 3,103,175.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 4,312,100.00 | 4,662,100.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 33,690,970.00 | 36,157,520.00 |
| 35600 | Мал амьтад | 20,314,000.00 | 20,314,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,960,991,283.06** | **1,854,815,789.49** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,960,991,283.06 | 1,854,815,789.49 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,936,033,283.06 | 1,829,947,789.49 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,617,565,421.34 | 1,713,762,777.34 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -270,905,745.34 | -416,341,780.76 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 161,150,000.00 | 221,150,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -68,133,333.58 | -97,775,000.38 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 202,509,848.00 | 214,242,368.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -45,274,932.36 | -98,491,774.11 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 53,683,190.00 | 57,583,190.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -23,309,130.32 | -31,080,299.67 |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 199,800,000.00 | 199,800,000.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | -42,624,000.00 | -50,616,000.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 229,493,158.20 | 229,493,158.20 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -78,238,192.88 | -112,095,849.13 |
| 39217 | Ном | 317,000.00 | 317,000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 24,958,000.00 | 24,868,000.00 |
| 39301 | Програм хангамж | 850,000.00 | 850,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -760,000.00 | -850,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 24,868,000.00 | 24,868,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,025,184,361.06** | **1,924,852,584.49** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **6,000.00** | **00.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 6,000.00 | 00.00 |
| **413** | **Өглөг** | 6,000.00 | 00.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 6,000.00 | 00.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 6,000.00 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,025,178,361.06** | **1,924,852,584.49** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,025,178,361.06 | 1,924,852,584.49 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 513,984,711.00 | 513,984,711.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 513,984,711.00 | 513,984,711.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,319,290,696.27 | 1,218,964,919.70 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,319,290,696.27 | 1,319,290,696.27 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -100,325,776.57 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 191,902,953.79 | 191,902,953.79 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,025,184,361.06** | **1,924,852,584.49** |

## 2.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,298,002,418.00** | **582,645,889.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **983,892,717.00** | **167,689,876.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 983,892,717.00 | 167,689,876.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 983,892,717.00 | 167,689,876.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 983,892,717.00 | 167,689,876.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **314,109,701.00** | **414,956,013.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 5,200,000.00 | 7,212,919.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,200,000.00 | 7,212,919.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 308,909,701.00 | 407,743,094.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 308,909,701.00 | 407,743,094.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **452,388,491.49** | **675,211,165.57** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **452,388,491.49** | **675,211,165.57** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 438,116,425.49 | 640,727,367.65 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 184,756,389.00 | 228,698,089.00 |
| 210101 | Үндсэн цалин | 184,756,389.00 | 228,698,089.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 23,327,161.00 | 28,585,162.08 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 16,813,518.00 | 17,517,871.65 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,545,662.00 | 6,141,198.37 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 873,601.00 | 1,257,977.90 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 287,122.00 | 316,301.15 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,807,258.00 | 3,351,813.02 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 12,371,597.50 | 40,235,204.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,108,281.00 | 6,141,633.00 |
| 210302 | Түлш, халаалт | 9,263,316.50 | 34,093,571.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 54,237,330.00 | 41,024,565.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,715,000.00 | 6,255,650.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 22,972,501.00 | 23,731,715.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 943,300.00 | 956,700.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 120,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 25,606,529.00 | 9,960,500.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 00.00 | 484,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 484,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,921,500.00 | 720,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,921,500.00 | 720,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 9,789,200.00 | 1,945,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,982,000.00 | 1,945,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 3,807,200.00 | 00.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 10,382,772.00 | 14,026,778.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 9,062,772.00 | 13,136,778.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 120,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,200,000.00 | 890,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 137,330,475.99 | 285,008,569.57 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,622,800.00 | 6,903,200.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 00.00 | 100,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 129,707,675.99 | 278,005,369.57 |

| | | | |
|---|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 14,272,066.00 | 34,483,797.92 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 12,900,000.00 | 00.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 12,900,000.00 | 00.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,360,000.00 | 26,362,700.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 23,812,700.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,360,000.00 | 2,550,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 12,066.00 | 8,121,097.92 |
| 213401 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага | 12,066.00 | 00.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 8,121,097.92 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **845,613,926.51** | **-92,565,276.57** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 53,348,429.07 | 7,760,500.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 53,348,429.07 | 00.00 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 00.00 | 7,760,500.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -53,348,429.07 | -7,760,500.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **792,265,497.44** | **-100,325,776.57** |

## 2.3 АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **323,408,685.00** | **414,956,013.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **5,000,000.00** | **00.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 5,000,000.00 | 00.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 5,000,000.00 | 00.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5,000,000.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **314,109,701.00** | **414,956,013.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 5,200,000.00 | 7,212,919.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,200,000.00 | 7,212,919.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 308,909,701.00 | 407,743,094.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 308,909,701.00 | 407,743,094.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 4,298,984.00 | 00.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 4,298,984.00 | 00.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **301,708,785.00** | **403,816,013.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **301,708,785.00** | **403,816,013.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **282,997,735.00** | **369,332,215.08** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 184,808,934.00 | 229,032,751.08 |
| 210101 | Үндсэн цалин | 154,737,526.00 | 191,952,851.08 |
| 210102 | Нэмэгдэл | 28,012,781.00 | 31,264,300.00 |
| 210104 | Урамшуулал | 2,058,627.00 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 00.00 | 5,815,600.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 23,195,700.00 | 28,256,500.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 15,700,200.00 | 19,288,600.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,873,900.00 | 2,336,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,499,100.00 | 1,688,400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 374,800.00 | 457,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,747,700.00 | 4,485,600.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 12,370,428.00 | 40,216,371.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,107,114.00 | 6,122,800.00 |
| 210302 | Түлш, халаалт | 9,263,314.00 | 34,093,571.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 24,563,400.00 | 28,718,850.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,727,900.00 | 5,143,150.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 20,272,200.00 | 19,600,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 943,300.00 | 956,700.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 20,000.00 | 360,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 600,000.00 | 2,659,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,344,700.00 | 2,700,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,344,700.00 | 2,700,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 9,982,000.00 | 1,945,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,982,000.00 | 1,945,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 4,000,000.00 | 00.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 16,639,233.00 | 22,922,643.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 14,855,101.00 | 20,463,431.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 250,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 50,000.00 | 00.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 70,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,664,132.00 | 2,209,212.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 9,093,340.00 | 15,540,100.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,000,000.00 | 15,440,100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 93,340.00 | 100,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **13,711,050.00** | **34,483,797.92** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 7,900,000.00 | 00.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 7,900,000.00 | 00.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 5,798,984.00 | 26,362,700.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 4,298,984.00 | 00.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 23,812,700.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,500,000.00 | 2,550,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 12,066.00 | 8,121,097.92 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 12,066.00 | 8,121,097.92 |

| | | | |
|---|---|---|---|
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **21,699,900.00** | **11,140,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **21,699,900.00** | **11,140,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **21,699,900.00** | **11,140,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 21,699,900.00 | 11,140,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 21,699,900.00 | 11,140,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-21,699,900.00** | **-11,140,000.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **00.00** | **00.00** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **00.00** | **00.00** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **00.00** | **00.00** |

## 2.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 513,984,711.00 | 201,421,973.88 | 527,025,198.83 | 1,242,431,883.71 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | -9,519,020.09 | 00.00 | -9,519,020.09 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 792,265,497.44 | 792,265,497.44 |
| C08 | **2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **513,984,711.00** | **191,902,953.79** | **1,319,290,696.27** | 2,025,178,361.06 |
| D01 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **513,984,711.00** | **191,902,953.79** | **1,319,290,696.27** | 2,025,178,361.06 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **513,984,711.00** | **191,902,953.79** | **1,319,290,696.27** | 2,025,178,361.06 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -100,325,776.57 | -100,325,776.57 |
| D09 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **513,984,711.00** | **191,902,953.79** | **1,218,964,919.70** | 1,924,852,584.49 |

## 2.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 409,019,100.00 | 400,044,344.08 | 8,974,755.92 | 97.8 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 409,019,100.00 | 400,044,344.08 | 8,974,755.92 | 97.8 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 382,656,400.00 | 373,681,644.08 | 8,974,755.92 | 97.7 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 229,139,100.00 | 229,032,751.08 | 106,348.92 | 100.0 |
| 210101 | Үндсэн цалин | 192,058,700.00 | 191,952,851.08 | 105,848.92 | 99.9 |
| 210102 | Нэмэгдэл | 31,264,800.00 | 31,264,300.00 | 500.00 | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 28,256,600.00 | 28,256,500.00 | 100.00 | 100.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,105,000.00 | 19,288,600.00 | -183,600.00 | 101.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,287,900.00 | 2,336,300.00 | -48,400.00 | 102.1 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,830,300.00 | 1,688,400.00 | 141,900.00 | 92.2 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,575,800.00 | 4,485,600.00 | 90,200.00 | 98.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 40,570,600.00 | 40,216,371.00 | 354,229.00 | 99.1 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,473,500.00 | 6,122,800.00 | 350,700.00 | 94.6 |
| 210302 | Түлш, халаалт | 34,097,100.00 | 34,093,571.00 | 3,529.00 | 100.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 29,297,700.00 | 29,171,762.00 | 125,938.00 | 99.6 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,596,300.00 | 5,596,062.00 | 238.00 | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,056,700.00 | 956,700.00 | 100,000.00 | 90.5 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,684,700.00 | 2,659,000.00 | 25,700.00 | 99.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 14,747,200.00 | 12,200,000.00 | 2,547,200.00 | 82.7 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 6,700,000.00 | 4,000,000.00 | 2,700,000.00 | 59.7 |
| 210602 | Тавилга | 5,250,000.00 | 5,500,000.00 | -250,000.00 | 104.8 |
| 210604 | Урсгал засвар | 2,797,200.00 | 2,700,000.00 | 97,200.00 | 96.5 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,937,600.00 | 1,945,000.00 | 2,992,600.00 | 39.4 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,937,600.00 | 1,945,000.00 | 2,992,600.00 | 39.4 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 19,963,800.00 | 17,319,160.00 | 2,644,640.00 | 86.8 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 16,149,800.00 | 13,672,860.00 | 2,476,940.00 | 84.7 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,564,000.00 | 3,396,300.00 | 167,700.00 | 95.3 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 15743800.00 | 15540100.00 | 203,700.00 | 98.7 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 15,443,800.00 | 15,440,100.00 | 3,700.00 | 100.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 300,000.00 | 100,000.00 | 200,000.00 | 33.3 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 409,019,100.00 | 400,044,344.08 | 8,974,755.92 | 97.8 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 409,019,100.00 | 400,044,344.08 | 8,974,755.92 | 97.8 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 409,019,100.00 | 400,044,344.08 | 8,974,755.92 | 97.8 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 24 | 20 | 4 | 83.3 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 9 | 5 | 4 | 55.6 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **24** | **20** | 4 | 83.3 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 9 | 5 | 4 | 55.6 |

## 2.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **5200000.00** | **6,790,571.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **5200000.00** | **6,790,571.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 5200000.00 | 6,790,571.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5200000.00 | 6,790,571.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5200000.00 | 6,790,571.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 5200000.00 | 6790571.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 5200000.00 | 6,790,571.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5200000.00 | 6,790,571.00 |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баянговь сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг ЗДТГ-ын дарга Д.Отгонжаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад анхаарах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 сарын 03-аас 2021 оны 02 сарын 05-ны хооронд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн хариуцаж хэрэгжүүлэв.

Баянговь сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх хүсэлтээ Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020.10.27-ны өдрийн 150 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Баянговь сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Монгол улсын засгийн газар, аймгийн ИТХ, Засаг даргаас тавьж буй хөтөлбөр зорилтыг хэрэгжүүлэх, сум, орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжлийн тогтвортой байдлыг хангах, хууль ёсыг чандлан сахиулж, төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй шуурхай хүргэхэд оршино” гэжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баянговь сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Санхүү, хяналт аудитын алба нь 2020 онд Баянговь сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж 8476.1 мянган төгрөгийн зөрчил илрүүлж төлбөрийн акт тогтоосон байна. Энэ шалгалтаар Баянговь сумын ЗДТГ-ын байр нь 2020.03.03-нд улсын комисс хүлээн авсан байхад тус барилгын 1, 2 дугаар сарын халаалтын төлбөрт 8258.0 мянган төгрөгийг төсвөөс төлсөнтэй холбоотой байна.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшин "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшин 2020 оны 3 дугаар улирлын нийт зардлын 452479.4 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 9049.6 мянга, гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшин 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 682971.7 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 13359.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж баталгаажуууллаа.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянговь сумын ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1924852.6 мянган төгрөг болж өмнөх оноос 100325.6 мянган төгрөгөөр буюу 5.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан ~~авлага,~~ бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 64,193.1 | 70,036.8 | 5,843.7 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 1,818.8 | 1,800.0 | (18.8) |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 62,374.2 | 68,236.8 | 5,862.6 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,960,991.3 | 1,854,815.8 | (106,175.5) |
| Үндсэн хөрөнгө | 2,490,236.6 | 2,662,066.5 | 171,829.9 |
| Хуримтлагдсан элэгдэл | (529,245.3) | (807,250.7) | (278,005.4) |
| Нийт хөрөнгө | 2,025,184.4 | 1,924,852.6 | (100,331.8) |
| Өр төлбөр | 6.0 | - | (6.0) |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 2,025,178.4 | 1,924,852.6 | (100,325.8) |

Авлага дансны үлдэгдэл 1800.0 мянган төгрөг болж 18.8 мянган төгрөгөөр буурч 2018 онд үүссэн 1800.0 мянган төгрөгийн “Очир заан” ХХК-аас авах биологийн дүгнэлтийн авлагыг барагдуулаагүйтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 68236.8 мянган төгрөг болж 5862.6 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материал 1500.0 мянга, бичиг хэргийн материал 1546.0 мянга, аж ахуйн материал 350.0 мянга, бусад хангамжийн материал 2466.6 мянган төгрөгөөр тус тус өссөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 171829.9 мянган төгрөг болж 106175.5 мянган мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 15632.5 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020.01.20-ны өдрийн 02 тоот тогтоолоор аймгийн ОНХС-гаар хийгдсэн 1 дүгээр багийн төвийн барилгыг 86197.4 мянган төгрөгөөр, сумын ИТХ-ын 2020.12.31-ний өдрийн 17 дугаар тогтоолоор ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар хог тээврийн автомашин 60000.0 мянга, цэвэр бохир усны шугам сүлжээ 10000.0 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус шилжүүлэн авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1924852.6 мянган төгрөг болж 100325.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 582645.9 мянган төгрөг болж өмнөх оноос 715356.5 мянган төгрөгөөр буюу 55.2 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 715356.5 мянган төгрөгийн орлого байна. Энэ нь орон нутгийн төсвөөс санхүүжилт 98833.4 мянга, нэмэлт санхүүжилтийн орлого 2012.9 мянган төгрөг тус тус өссөн, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 816202.8 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Нийт зардал 675211.2 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 218523.7 мянган төгрөгөөр буюу 47.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд байна. Энэ нь ҮХЭЗ 148297,7 мянга, цалин, хөлс болон нэмэгдэл урамшил 43941,7 мянга, НДШ 5258,0 мянга, гэрэл цахилгаан 3033,3 мянга, түлш халаалт 24830,2 мянга, бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбоо, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал,бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардал, урсгал шилжүүлгийн зардал өссөнтэй холбоотой байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 410471.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 410471.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 547.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 411019.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд анх баталсан 411019.1 мянган төгрөгийг тодотголоор 2000.1 мянган төгрөгөөр бууруулж 409019.0 мянган төгрөгөөр баталсан байна.

**Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 411019.1 мянган төгрөгийн төсөв батласнаас 410019.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 407743.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, нэмэлт санхүүжилтийн дансанд 7212.9 мянган төгрөг оруулж, урсгал үйл ажиллагаанд 406834.8 мянган төгрөгийг зарцуулж, 8121.1 мянган төгрөгийг орон төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл  мянган төгрөг буюу 97.8 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил 106,3 мянга, байр ашиглахтай холбоотой зардал 354.2 мянга, хангамж, бараа материалын зардал 125.9 мянга, эд хогшил урсгал засварын зардал 2547.2 мянга, томилолт зочны зардал 2992.6 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж  2644.6 мянга, бусад бараа үйлчилгээний зардал 203.7 мянган төгрөг тус тус хэмнэсэн байна.

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| ХӨТӨЛБӨР 70106 | | | | |
| АРГА ХЭМЖЭЭ 80101 | | | | |
| НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 311,426,900.00 | 302,030,099.08 | 9,396,800.92 | 96.98 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 311,426,900.00 | 302,030,099.08 | 9,396,800.92 | 96.98 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 311,426,900.00 | 302,030,099.08 | 5,496,818.92 | 96.98 |
| Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 202,981,600.00 | 198,975,369.08 | 106,248.92 | 98.03 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 21,799,000.00 | 21,799,000.00 | 0.00 | 100.00 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 43,519,800.00 | 39,619,818.00 | 3,899,982.00 | 91.04 |
| Хангамж, бараа материалын зардал | 22,888,000.00 | 22,837,062.00 | 50,938.00 | 99.78 |
| Нормативт зардал | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 11,700,000.00 | 11,700,000.00 | 0.00 | 100.00 |
| Томилолт, зочны зардал | 2,984,300.00 | 1,945,000.00 | 1,039,300.00 | 65.17 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 5,254,200.00 | 5,053,850.00 | 200,350.00 | 96.19 |
| Бараа үйлчилгээний бусад зарда | 6,943,800.00 | 6,943,400.00 | 400.00 | 99.99 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага | 300,000.00 | 100,000.00 | 200,000.00 | 33.33 |
| ХӨТӨЛБӨР 70106 | | | | |
| АРГА ХЭМЖЭЭ 80106 | | | | |
| НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 70,289,800.00 | 68,951,463.00 | 1,338,337.00 | 98.10 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 70,289,800.00 | 68,951,463.00 | 1,338,337.00 | 98.10 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 70,289,800.00 | 68,951,463.00 | 1,338,337.00 | 98.1 |
| Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 54,396,300.00 | 54,396,300.00 | 0.00 | 100.00 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 6,457,500.00 | 6,457,500.00 | 0.00 | 100.00 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 823,000.00 | 596,553.00 | 226,447.00 | 72.49 |
| Хангамж, бараа материалын зардал | 6,434,700.00 | 6,334,700.00 | 100,000.00 | 98.45 |
| эд хогшил урсгал засвар | 500,000.00 | 500,000.00 | 0.00 | 100.00 |
| Томилолт зочны зардал | 953,300.00 | 0 | 953,300.00 | 0.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж | 175,000.00 | 116,410.00 | 58,590.00 | 66.52 |
| Нэг удаагийн тэтгэмж, шаг урам | 550,000.00 | 550,000.00 | 0.00 | 100.00 |
| ХӨТӨЛБӨР 70106 | | | | |
| АРГА ХЭМЖЭЭ 80802 | | | | |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 25,812,700.00 | 25,812,700.00 | 0.00 | 100.00 |
| Бусад урсгал шилжүүлэг | 25,812,700.00 | 25,812,700.00 | 0.00 | 100.00 |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 23,812,700.00 | 23,812,700.00 | 0.00 | 100.00 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,000,000.00 | 2,000,000.00 | 0.00 | 100.00 |
| ХӨТӨЛБӨР 70106 | | | | |
| АРГА ХЭМЖЭЭ 81102 | | | | |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 8,500,000.00 | 8,496,700.00 | 3,300.00 | 99.96 |
| Бусад урсгал шилжүүлэг | 8,500,000.00 | 8,496,700.00 | 3,300.00 | 99.96 |
| Бараа үйлчилгээний бусад зарда | 8,500,000.00 | 8,496,700.00 | 3,300.00 | 99.96 |
| ХӨТӨЛБӨР 70106 | | | | |
| АРГА ХЭМЖЭЭ 82212 | | | | |
| НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 14,284,700.00 | 12,148,900.00 | 2,135,800.00 | 85.05 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 14,284,700.00 | 12,148,900.00 | 2,135,800.00 | 85.05 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 14,284,700.00 | 12,148,900.00 | 2,135,800.00 | 85.05 |
| Бусад нийтлэг АҮТХураамж | 14,284,700.00 | 12,148,900.00 | 2,135,800.00 | 85.05 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

**Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Статистикийн хэлтсээс хүн ам, орон сууцны тооллогын зардалд 180.0 мянга, малын ашиг шимийн судалгааны зардал 530.4 мянга, хагас жилийн мал тооллогын зардал 717,5 мянга, "Вита майн компани" дэнчингийн 2000.0, цахим тендерийн хураамж 1085,0 мянга, "Солид трейд" ХХК барьцаа 500,0, Хамтарсан багийн үйл ажиллагааны зардал 2000,0 мянга, эмнэлгийн ажилчдаас сумын онцгой комисст 200.0 нийт 7212.9 мянган төгрөгийн орлого төвлөрч, 6790,6 мянган төгрөгийг зарцуулж 422.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 111 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроож байршуулсан 38 байгаа бөгөөд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 2 гүйлгээний 49985.2 мянга, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний 19600.0 төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

| д/д | Хугацаа | Төрөл | Удаа | Хугацаанд оруулсан | Хугацаа хоцроосон | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 6 | 3 | 2 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 2 | 2 | |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 2 | 2 | |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 32 | 4 | |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 69 | 27 | |
| | Нийт | 27 | 151 | 111 | 38 | 2 |

**3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх аудитаар 792.9 сая төгрөгийн зөрчил илэрч 2 албан шаардлага, 1 төлбөрийн акт тогтоож акт, албан шаардлагын биелэлтийг

**3.9. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 3500.0 мянган төгрөгийн зөрчил илэрч 2000.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 1500 мянган төгрөгийн зөвлөмж өгөв

**Залруулсан алдаа.**

Байхгүй

**Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 3500.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 2000.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 1500,0 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 2 заалт бүхий зөвлөмж өгөв. Үүнд:

1. Санхүүгийн албаны дарга Г. Гаваад ММНБИ-ээс зохион байгуулсан мэргэшсэн нягтлан бодогчийн онлайн сургалтын төлбөрийн 1000.0 мянган төгрөгийг бусад бараа үйлчилгээний зардлаас олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5."Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 6 дугаар зүйлийн 6.4.1."Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Г.Гаваад олгосон сургалтын төлбөрийн 1000.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох

2. Баянговь сумын Засаг даргын 2020.04.13-ы өдрийн 35 дугаар захирамжаар бараа үйлчилгээний бусад зардлаас цэрэг татлага зохион байгуулах хоолны цайны зардалд 1000.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.

Энэ нь нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5."Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" 6 дугаар зүйлийн 6.4.1."Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Цэргийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6."Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга цэрэг татлага явуулахад шаардлагатай байр, тээврийн хэрэгслээр хангаж, дэмжлэг үзүүлэх албан тушаалтныг томилж ажиллуулах үүрэгтэй" заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цэрэг татлагын арга хэмжээнд зарцуулсан 1000.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох

Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.9. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Байхгүй

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

*1.1 <u>Илрүүлэлт</u>*

Ахмадын баярыг тохиолдуулан 1 мөнгөн аяга худалдан авч сумын Засаг даргын 2020.11.25-ны өдрийн 92 дугаар захирамжаар Засаг даргын нөөц хөрөнгөөс ахмадын баярын үйл ажиллагаанд "ГОВЬ ЭКО ФҮҮДС" ХХК-д 250.0 мянган төгрөг шилжүүлж мөнгөн аяга авч шагналд өгсөн байна.

Энэ нь нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5."Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг Даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.2.1.2 "Энэ журмын 2.1.1,2.1.2-т зааснаас бусад зориулалтаар тоног төхөөрөмж бэлтгэх, хөрөнгө оруулалтын зардал гаргах" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

*<u>1.2. Эрсдэл</u>*

Засаг даргын нөөц хөрөнгө, мөрийн хөтөлбөрийн зардлыг зориулалт бусаар зарцуулах.

*1.3 <u>Өгсөн зөвлөмж</u>*

Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулахдаа Засгийн газрын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам"-ын дагуу зориулалт бус үйл ажиллагаанд зарцуулдаг явдлыг таслан зогсоож, зориулалтын дагуу зарцуулж байх

*<u>1.4.Байгууллагаас өгсөн хариу тайлбар</u>*

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

*<u>2.1.Илрүүлэлт</u>*

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 111 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроож байршуулсан 38 мэдээлэл байгаа бөгөөд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 2 гүйлгээний 49985.2 мянга, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний 19600.0 төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

*<u>2.2 Эрсдэл</u>*

Хуульд заасан мэдээллийг байршуулаагүй байх

*<u>2.3 Өгсөн зөвлөмж</u>*

Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 .дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" 6.4 " Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсний дагуу дээрх хугацаа хоцроож байршуулсан мэдээллийг хугацаанд мэдээлж байх.

*<u>2.4.Байгууллагаас өгсөн хариу тайлбар</u>*

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

*<u>2.5.Байгууллагаас өгсөн хариу тайлбар</u>*

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 04 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР Н.БҮНЧИНСҮРЭН

ОГНОО: 2021.02.25

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦЭЭНЯМ

ОГНОО: 2021.02.25

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

ОГНОО: 2021.02.25

## 5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо: | Аудитын нэр: | 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит | Аудитын код: |
|---|---|---|---|
| 2021 | | | БНА-2021/17/СТА-ТШЗ |

| Шалгагдсан байгууллагын нэр: | Баянговь сумын Засаг даргын Тамгын газар | Мянган төгрөг |
|---|---|---|

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Бусад бараа үйлчилгээний зардлаас Санхүүгийн албаны дарга Г.Гаваад сургалтын төлбөрт 1000.0 мянган төгрөг олгосон байна. | 1000.0 | Төлбөрийн акт тогтоох | Дарга Нягтлан бодогч | Д.Отгонжаргал Э.Пүрэвжаргал |
| 2 | Баянговь сумын Засаг даргын 2020.04.13-ы өдрийн 35 дугаар захирамжаар бараа үйлчилгээний бусад зардлаас цэрэг татлага зохион байгуулах зардалд 1000.0 мянган төгрөгийг хоол цайны зардлыг шилжүүлсэн байна. | 1000.0 | Төлбөрийн акт тогтоох | Дарга Нягтлан бодогч | Д.Отгонжаргал Э.Пүрэвжаргал |
| 3 | Засаг даргын нөөц хөрөнгөнөөс зориулалт бусаар зардал гаргасан байна | 250.0 | Зөвлөмж өгөх | Дарга Нягтлан бодогч | Д.Отгонжаргал Э.Пүрэвжаргал |
| 4 | Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 111 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроож байршуулсан 38 мэдээлэл байна. | 0 | Зөвлөмж өгөх | Дарга Нягтлан бодогч | Д.Отгонжаргал Э.Пүрэвжаргал |
| **Нийт дүн** | | **2250.0** | | | |